

орнууд мөн Япон, Хятадыг оролцуулсан Азийн чөлөөт худалдааны бүс байгуулах оролдлогыг хийв. «НАФТА», «Европын холбоо» хүчтэй болоод худалдааны бүлэглэл бий болох үед энэ байгууллагын үйл ажиллагаа АНД-д идэвхтэй болж болох юм.

Зүүн хойт Азийн (ЗХА) орнуудыг нэгтгэсэн худалдаа эдийн засгийн байгууллага байгуулах идэвхтэй оролдлого гишүүн орнууд гаргаж байна. XXI зуунд ЗХА-ийн улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага бий болоход эргэлзэх зүйлгүй. Түүний үндэс суурийн эхлэл болсон «Түмэн голын» төсөл нь Түмэн голын бүсийн хөгжлийн корпораци, Засгийн газар хоорондын зохицуулах, зөвлөлдөх комисс байгуулах явцдаа байна.

ЗХА-ийн хамтын ажиллагааны бүсд манай орон ямар хэмжээгээр аль салбарт хэрхэн оролцох, өөрийн ирээдүйн төлөвөө бид одооноос нарийвчлан боловсруулж гаргах явдал чухлаар тавигдаж байна. АНД-д ЗХА-ийн эзлэх хувийн жин, үүрэг маш ихээр өсч тэргүүлэх байр сууриа XXI зуунд эзлэх төлөвтэй байгааг бид одооноос бодолцон ажиллах шаардлага гарч байна. Иймд уг асуудлыг зангидан зохицуулж, ЗХА-д ажиллах өөрийн орны хэтийн төлөвийг бодон, Засгийн газрын дэргэд тусгай хороо байгуулах цаг болсон мэт санагдана.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. 1993 оны 5 дугаар сард Токиод «Дэлхий дахины өөрчлөгдөж байгаа дэг журам дахь Азийн роль» сэдвээр болсон олон улсын бага хурал дээр Ази, Номхон далайн орнуудын төр засгийн тэргүүд, орлогчдын хэлсэн үг.
2. Far Eastern Economic Review сэтгүүлийн
 - 1991 оны 7 дугаар сарын 25,
 - 1993 оны 4 дүгээр сарын 15
 - 1993 оны 3 дугаар сарын 25
 - 1993 оны 3 дугаар сарын 18
 - 1993 оны 3 дугаар сарын 11
 - 1993 оны 9 дүгээр сарын 2
 - 1993 оны 12, 11-р сарын дугаарууд
3. The Economist сэтгүүлийн 1993 оны 3, 4, 10, 11-р сарын дугаарууд
4. Pacific Affairs 1989 оны № 4

ВЬЕТНАМ, МОНГОЛЫН ХАРИЛЦАА ӨНӨӨГИЙН ШАТАНД

Ле Ван Зыенг*
С. Дашцэвэл

Дэлхийн үйлдвэрлэх хүч өнөө үед дээд хэмжээгээр интернационалчлагдаж улмаар тэр нь өнөөгийн улс төр, эдийн засгийн харилцаанд нөлөөлж байна. Эдүгээ дэлхий ертөнц нэгдсэн нэгэн зах зээл болон хувирч тэрхүү дэлхийн нэгдмэл зах зээл “Дэлхийн хэмжээний хөдөлмөрийн хуваарийг шаардаж эхлээд байна. Зарим судлаачид улс төрчдийн үзэж буйгаар хөдөлмөрийн хуваарь хэдийчинээ өндөр байна харилцан хамаарал төдийчинээ их байх бөгөөд харилцан хамаарал нь улс үндэстнүүдийн өөрийн өвөрмөц шинж төрхийг хамгаалж хөгжүүлэх боломжийг алдахгүй харин ч дэлхийн хэмжээнд улам бүр нягт

* ДДОУС-ын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

* ДДОУС-ын Хүрээлэнгийн аспирант

хамтран ажиллах явцад давуу талаа хөгжүүлэхийг улс үндэстэн бүрээс шаардах болно хэмээн үзэж байна¹.

Энэхүү үзэл, ойлголтыг хүлээн зөвшөөрвөл олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхитэй оролцох хэрэгцээ шаардлага, бусад улс орнуудын эдийн засгаа хөгжүүлж буй хүчин чармайлт, хөгжлийн туршлага зэргийг зөв үнэлэх боломж олгоно.

Олон улсын харилцааны хувьд бидний улс төрийн сэтгэлгээ хүйтэн дайн, дэлхийн хоёр системийн сөргөлдөөний нөхцөлд дэлхий ертөнцийг зөвхөн үзэл суртлын хэмжүүрээр тодорхойлж дэлхийн улс орнуудтай харилцахдаа ялгаварт зарчмыг (социалист интернационализм, энх тайвнаар зэрэгцэн орших гэх мэт) хэрэглэж өөрийгөө дэлхийн эдийн засгийн харилцаа холбооноос зохиомлоор тусгаарлан эдийн засаг, технологийн хоцрогдолд хүргэж байлаа.

Монгол улс, БНСВУ гадаад бодлогынхоо өнөөгийн чиг шугамыг орчин үеийн дэлхий ертөнцийн хөгжлийн хандлагад тулгуурлан тодорхойлж байна.

БНСВУ улс төр, нийгмийн байгууллагаар үл ялгаварлан бүх улс оронтой хамтын ажиллагааг өргөжүүлэхээ нийтэд тунхаглан² хэрэгжүүлж байгаа бол Монгол улс дэлхийн улс түмэнтэй харилцахдаа үзэл суртал, шашин шүтлэг, том багын аливаа ялгааг харгалзахгүй товчоор хэлбэл тухайн орны хөгжих замаа сонгох эрхийг нь хүндэтгэх зарчим баримталж, нэг тулгуурт бодлогоос олон тулгуурт гадаад бодлогод шилжиж байна³.

Энхийг эрхэмлэсэн нээлттэй гадаад бодлогыг хэрэгжүүлж байгаа БНСВУ Зүүн өмнөд Ази, Ази номхон далайн бүс нутгийн улс орнуудтай харилцаагаа хөгжүүлэх нь Вьетнамын болон бүс нутгийн ашиг сонирхолтой нягт холбоотой гэсэн үзэл бодлын үүднээс юуны өмнө хөрш зэргэлдээ улсуудтайгаа харилцааг өргөжүүлэхэд онцгой анхаарч байна.

Монгол улс өнөөгийн гадаад бодлогын чиг шугамдаа зохицуулалт хийхдээ ганц нэгхэн орныг түших өрөөсөл арга барилаа өөрчилж хоёр том хөрш Хятад, Оростой , харилцааг тэнцвэртэй хөгжүүлж, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд гишүүнээр элсэн орж, Ази, Номхон далайн бүсийн орнууд ялангуяа зүүн хойт Ази, Төв Азийн бүс нутгийн, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх арга замыг идэвхийлэн сүвэгчилж, үүд хаалгаа өргөнөөр нээж байна.

Хүйтэн дайны үеийн хэвшил болсон зарчим, үзэл сурталд үндэслэн үүсч хөгжсөн Вьетнам, Монголын харилцаа эдүгээ харилцааны шинэ зарчмын хамт шинэ цаг үед шилжин орлоо.

1990-ээд оноос эхлэн бидний харилцаа ганц нэг ангийн биш нийт үндэсний ашиг сонирхлыг дээдэлж, эрх тэгш харилцан ашигтай байх зарчимд үндэслэсэн мөн зах зээлийн эдийн засгийн тогтолцооны нөхцөлд тохирсон тийм харилцааг хөгжүүлэх боллоо.

1991 онд засгийн газрын төлөөлөгчид 1991-1995 оны худалдааны болон төлбөрийн тухай хэлэлцээнд гарын үсэг зурж, 1991 оноос хоёр талын худалдааг шинэ тогтолцооны дагуу хийхээр тохиролцов.

Шинэ хэлэлцээр ёсоор, Вьетнам, Монголын гадаад худалдааг «эрх тэгш, харилцан ашигтай байх зарчим, олон улсын худалдааны дүрэм, журам болон практикийг мөрдөх» үндсэн дээр цаашид өргөжүүлэн хөгжүүлэх юм.

Хэлэлцээрт барааны нэр төрлийг заагаагүй бөгөөд хоёр талын аж ахуйн байгууллагууд барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ мөнгийг харилцан тохиролцож, дэлхийн зах зээлийн үнийг үндэслэн чөлөөт валютаар төлбөрийн тооцоо хийхээр тохиролцсон юм.

Хоёр орны гадаад худалдааг цаашид хөгжүүлэх аятай нөхцөлийг бий болгохын тулд худалдаа, тээврийн салбарт үндэсний нэн тааламжтай нөхцөлийг бие биедээ харилцан олгоно гэж хоёр тал тохиролцсноос гадна бараа солилцох, үзэсгэлэн гаргаж сурталчилгаа хийх гэх мэт гадаад худалдааны практикт нийцсэн худалдааны бусад олон хэлбэрийг дэмжиж байгаа билээ.

Засгийн газар хоорондын төлбөрийн тухай хэлэлцээрээр 1991 оны 1-р сарын 1-нээс эхлэн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүх төлбөр тооцоог олон улсын худалдааны нөхцөл практик болон орон тус бүрийн валютын дүрэм журмын дагуу тухайн бараа, үйлчилгээний Дэлхийн зах зээлийн үнээр чөлөөт хөрвөдөг валютаар гүйцэтгэх болов. Худалдааны бус бүх төрлийн төлбөр тооцоог ч гэсэн чөлөөт валютаар хийх болсон юм.

Ийнхүү хоёр улсын засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээрээр худалдаа, төлбөрийн тухай зарчмын асуудлуудыг шийдэж, гадаад худалдааг хөгжүүлэх таатай боломж бүрдүүлсэн боловч өнөөг хүртэл хоёр улсын болон янз бүрийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хоорондын худалдаа, бараа солилцоонд ахиц дэвшил гарсангүй. Харилцан бие биенийхээ зах зээл, хамтын ажиллагааны боломж нөхцөлийг сонирхон судлах идэвхи чармайлт ч төдийлөн гарсангүй. 80-аад оны эцсээс эхлэн хоёр улсын нийт бараа эргэлтийн хэмжээ буурсаар эдүгээ 1993 онд тэг цэгт тулж ирээд байна.

Энэ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй шилжилтийн өнөө үед хоёр улс хоёулаа эдийн засаг, нийгмийн хямралаас гарч чадаагүй, хөрөнгө бэл, техник технологийн хувьд ядуу, хөрөнгө оруулах боломж, туршлага багатайн дээр хоёр улсын хоорондох, тээврийн нөхцөл муу зэрэг үндсэн шалтгаантай холбоотой.

Хоёр улсын худалдаа эдийн засгийн харилцаа ийнхүү түр зуурын зогсонги байдалд байгаа ч гэсэн наанадаж, 700-аад жилийн өмнөөс эхлэлтэй бидний харилцааны өнө эртний уламжлал тасрахгүй бөгөөд үлэмжхэн нөөц ирээдүй бий.

Эдийн засгийн хувьд хамгийн их хурдтай хөгжиж байгаа, XXI зуунд дэлхийн хөгжлийн төв болох ирээдүйтэй Ази-Номхон далайн бүс нутагт оршдог манай хоёр орон хөгжлийнхөө явцад олон шижмээр холбоотой байхаас өөр арга байхгүй. Гагцхүү хоёр орны хувьд хамгийн үр ашигтай хамгийн тохиромжтой хамтын ажиллагааны хэлбэрүүдийг хоёр улсын болон олон улсын хүрээнд сонгон олох нь чухал байгаа юм. Вьетнам, Монгол хоёр улс бол хөгжиж байгаа орнууд бөгөөд эгнээндээ 108 том жижиг улсыг багтаасан эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн билээ. Иймд хоёр орны харилцааны хөгжлийн асуудлаас гадна 77-ийн бүлэг, НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллагууд зэрэг олон улсын байгууллагын хүрээнд дэх нийтлэг асуудлууд бүс нутгийн болон дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахад үйл ажиллалагаагаа уялдуулан зохицуулахыг шаардаж байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн зүтгэлтнүүд, эрдэмтдийн уулзалт, олон улсын хурал зөвлөлгөөн зохион байгуулж Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж өнөөгийн шинэ нөхцөлөөс урган гарсан хойшлуулшгүй олон асуудлыг шийдвэрлэх зүй зохистой арга замыг хамтран эрж олох нь чухал байна.

Вьетнам бол Зүүн өмнөд Ази, Зүүн хойд Азийн заагт оршдог гэж. хэлж болохоор байршилтай Зүүн өмнөд Азийн орон. Вьетнам улс алхам алхамаар бүс нутгийн хамтын үйл ажиллагаанд нэгдэн оролцох

боллоо. 1991 онд Зүүн өмнөд Азийн орнуудын Балийн гэрээнд оролцсон бөгөөд цаашдаа Зүүн өмнөд Азийн улсуудын холбоонд (АСЕАН) элсэн орох бэлтгэл хийж байна. Гадаад бодлогодоо зөвхөн хөрш зэргэлдээ улсууд төдийгүй Зүүн хойд Азийн улс орнуудыг анхааран үзэж, тэдгээр оронтой нягт харилцах нь вьетнамын ашиг сонирхолд нийцнэ хэмээн үзэж байна.

Зүүн хойд Азид оршдог Монгол улсын хувьд хөрш зэргэлдээх хоёр. том гүрэн Зүүн хойд Азийн улс орнуудтай харилцаагаа хөгжүүлэхэд юуны өмнө анхаарч буйгаас гадна Ази, Номхон далайн улсууд, түүний дотор Зүүн өмнөд Азийн улсуудтай харилцаагаа хөгжүүлэх сонирхолтой билээ. БНСВУ Зүүн өмнөд Азид нэвтрүүлэх үүд хаалгын нэг байх боломж ч бий. Энэ үүднээс үзвэл Вьетнам, Монгол хоёр орны гадаад бодлогын чиг шугамд харилцан бие биентэйгээ харилцааг хөгжүүлэх нийтлэг зорилт агуулагдаж байгаа бөгөөд гагцхүү хэрхэн хэрэгжүүлэх арга замаа тодорхойлох үе шатанд тулж ирчихээд байгаа юм.

Орчин үеийн олон улсын харилцааны гол зорилго, агуулга хамтран ажиллах, хөгжин цэцэглэхэд чиглэгдэж байна. Тийм ч учраас эдийн засаг, худалдааны харилцаа эн тэргүүнд тавигдаж байна. Тус хоёр улс эдийн засгийн хаалгаа чөлөөтэй нээж зах зээл, худалдааны түнш хайж, гадаадын хөрөнгө оруулалт сонирхож байгаа өнөө үед шинээр хөгжиж байгаа эдийн засагтай, байгалийн баялаг, хөдөлмөрийн нөөц ихтэй ч хөрөнгө бэл, техник-технологи, бизнесийн туршлага багатай хоёр орны хувьд бусад орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн хамт, өвөр хоорондоо уламжлалт харилцаа хамтын ажиллагаа уламжлалт зах зээлээ таслахгүй харилцан үр ашигтай чиглэлээр шинэчлэн хөгжүүлэх шаардлагатай. Үүний тул дараах зарим арга хэмжээг яаралтай хэрэгжүүлүүштэй байна. Хоёр улсын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны засгийн газар хоорондын комиссын үйл ажиллагааг өнөөгийн нөхцөлд тохируулан шинэчлэхийн тулд зохион байгуулалт үйл ажиллагааны шинэ тогтолцоог бий болгох, хоёр улсын янз бүрийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хооронд шууд харилцааг дэмжиж түүний үндсэн дээр хамтын ажиллагааны хэлбэр, хэмжээ далайц, хэрэгжүүлэх арга замаа сонгож, дараа нь хоёр улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны ерөнхий хэлэлцээрийн дагуу тодорхой гэрээнүүдийг эцэслэн гүйцэтгэх нь амьдралд нийцтэй болох талтай.

Хэдийгээр хоёр улсын худалдааны харилцаа орон тус бүрийн гадаад худалдааны нийт хэмжээний өчүүхэн хувийг (1%) эзлэх боловч Вьетнам, Монголын эдийн засгийн харилцаанд голлох байр эзэлсээр байна. Магадгүй цаашдаа ч хоёр улсын худалдаа голлох үүрэгтэй хэвээр байх үндэстэй. Учир нь хамтран ажиллах, хөрөнгө оруулах боломж аль алинд нь их биш билээ. Тийм ч учраас харилцан нийлүүлдэг уламжлалт бараагаа бусад улсад алдахгүй гадаад худалдааны бусад нөөц бололцоогоо дээд зэргээр ашиглахын тулд уламжлалт болон бусад барааныхаа үйлдвэрлэлийн чанар, үр ашгийг дээшлүүлэхэд аль аль тал нь анхаарах шардлага гарч байна.

Өнөөгийн өөрчлөлт шинэчлэлийн үед тус хоёр орны хувьд дунд болон жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх нийтлэг хэрэгцээ сонирхол өсч байна. Энэ салбарт Вьетнам улс арай илүү туршлагатай. Хоёр тал Энэ талаар харилцан туршлага судалж улмаар хамтран ажиллах боломж бий. Юуны өмнө хүнсний төрлийн бүтээгдэхүүн, эмийн зүйл үйлвэрлэх жижиг үйлдвэр байгуулах нь хоёр талд арай илүү дөхөмтэй.

Хоёр улсын эдийн засаг, худалдааны харилцаанд нөлөөлж байгаа нэг томоохон саад бэрхшээл гэвэл зам тээврийн асуудал билээ. Ирээдүйд Таньжин боомтоор нэвтрэх Монголын далайн гарц бүрмөсөн хэрэгжиж, Ханой-Бээжингийн төмөр замын шугам сэргэж, Улаанбаатарыг дайран Ази-Европыг холбосон агаарын зам нээгдвэл хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжих сайхан хэтийн төлөв нээгдэнэ. Тэр үед вьетнамын бараа Монголыг дайран орж, зүүн европын орнуудад, монголын бараа Вьетнамыг дайран Зүүн өмнөд Азийн орнуудад хүрэх боломжтой. Иймд хамтын ажиллагааны ирээдүйн хөгжлийг тодорхойлохдоо энэхүү хүчин зүйлийг эрх биш тогтоох шаардлагатай.

Өнөөгийн нөхцөлд соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ хэлбэрийг сонгож олох нь нэн чухал. Юуны өмнө хоёр талын уламжлалт хөдөө аж ахуй, мал эмнэлэг, ардын эмнэлэг, урлаг соёл гэх мэтийн салбарт мэргэжилтэн бэлтгэх ажлыг цаашид үргэлжлүүлж болох юм. Улсын их дээд сургуулиас гадна хувийн дээд сургууль ажиллаж байгаа өнөө үед улсын зардлаар төдийгүй хувийн шугамаар мэргэжилтэн харилцан бэлтгэх өргөн боломж нээгдэж байна.

Хоёр ард түмний түүх соёлыг танилцуулж сурталчлах олон хэлбэрийн үйл ажилалгаа цаашид өргөжин тэлэх боломжтой. Үүнд урлагийн хамтлагууд болон уран бүтээлчдийг солилцох, жуулчлалын салбарыг хөгжүүлэх, урлаг соёлын бүтээл солилцож төрөл бүрийн үзэсгэлэн гаргах, хоёр орны шилдэг сонгодог уран зохиолыг эх хэлнээс нь хөрвүүлж танилцуулах гэх мэт олон хэлбэрийн ажил багтана. Эдүгээ олон нийтийн байгууллагууд сайн дурын үндсэн дээр доороосоо олноор байгуулагдан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд дээрх ажлыг өрнүүлэх боломж улам бүр өргөжиж байна. Эдгээр үйл ажиллагаанд хоёр улсын их сургуульд суралцан төгсөгчдийн идэвхи санаачлага чухал үүрэг гүйцэтгэнэ.

Эрх баригч ВКН, МАХН уламжлалт харилцаатай билээ. Эдүгээ Шинэчлэлийн нөхцөлд хоёр намын шинж чанарын хувьд зарчмын чанартай зарим ялгаа бий боловч уламжлалт харилцаагаа хадгалан цааш хөгжүүлэх боломжтой бөгөөд урьдынх шиг харилцаа үгүйлэгдэж байна. МАХН-ын XXI их хурлаас «гадаад орнуудын улс төрийн намуудтай харилцах нь улс орны гадаад харилцааны орон зайг тэлж, эх орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тус үзүүлэхэд чиглэх болно»⁴ гэж онцлон тэмдэглэсэн билээ. Энэ хүү үзэл санааны дагуу эрх баригч хоёр намын харилцаа цаашид гүнзгийрэн хөгжих бүрэн үндэстэй юм.

Эдүгээ Монгол улсад 1992 оны бүх нийтийн чөлөөт сонгуулиар ялсаг эрх баригч МАХН-аас гадна улс төрийн хэд хэдэн намууд үндсэн хуулийнхаа дагуу албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. ВКН өөрийн улс төрийн чиг бодлогод энх тайван, үндэсний тусгаар тогтнол, ардчилал, нийгмийн дэвшлийн төлөө тэмцэж байгаа бүх хүчинтэй эв санааны нэгдэлтэй байхаа илэрхийлж мэдэгдэхдээ: «Дэлхийн бүх социал-демократ болон ардчилал дэвшлийн төлөө хөдөлгөөнтэй харилцаа тогтоон өргөжүүлэхэд бэлэн байна»⁵ хэмээсэн билээ. Энэ хүсэл сонирхлынхоо дагуу Монголын Үндэсний Ардчилсан нам, Монголын Социал Демократ Нам, ВКН-ын хооронд хоёр улсын үндэсний эрх ашигт нийцсэн найрсаг харилцааг үүсгэн хөгжүүлэх зүй зохистой хэлбэрийг ч эрж хайж болох юм.

Өнөөгийн шилжилтийн шатанд саад бэрхшээл тохиолдож байгаа ч гэсэн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны 40-өөд жилийн уламж-

лалтай манай хоёр улсын харилцаа өөрчлөлт шинэчлэлийн шинэ нөхцөлд ард түмнийхээ ашиг сонирхол, шинэчлэгдэж буй нийгмийнхээ хэрэгцээ шаардлагын дагуу бүх талаар өргөжин хөгжих хэтийн сайхан нэгтгэсэн, төлөв бий.

- 1 Nguyen Co Thach. Tat ca vi hoa binh, doc lap dan toc va phat trien Tap chi congsan, 1989 № 8, p. 13.
2. Bao «Nhandan» 16 3. 1991
3. Ардын эрх, 1992, № 25
4. Үнэн, 1992, № 21
5. Van kien Dai hoi dai bieu toan quoc lan thu VII Hanoi, 1994, p. 89.

АЗИЙН ОРНУУД БА
ШИНЭТГЭЛ

**СОЛОНГОСЫН ШИНЖЛЭХ УХААН-
ТЕХНИКИЙН ДЭВШИЛ:
ТУРШЛАГА, СУРГАМЖ**

Д. Баатар*
Н. Ишжамц

Энэ оны 6-р сард бид БН Солонгос улсын үндэсний ШУА-ийн гишүүн, оюун соёл судлалын академийн ерөнхийлөгч, академич Ли Хюн Лайн урилгаар Өмнөд Солонгосд хэд хоног айлчилж, тэндэхийн шинжлэх ухаан-техник, дээд боловсролын гол байгууллагуудын удирдлага, мэргэжилтэн нартай уулзаж, хөгжил дэвшлийнх нь стратегийн бодлого, арга туршлага, сургамж төлөвтэй танилцаж, нилээд тухтай санал солилцох аятай боломж гарсан юм. Солонгосын оюун-соёл судлалын академи, Үндэсний шинжлэх ухааны академи, Соёлын яам, Шинжлэх ухаан-техникийн академийн харьяа Генетикийн удамшлын инженерчлэлийн судалгааны хүрээлэн, электронт техникийн Самсунг компани, Тайжон хотын Шинжлэх ухааны хотхон дахь Олон улсын шинжлэх ухаан, техникийн «ЭКСПО-93» үзэсгэлэнгийн зохион байгуулах хороо, байр байдал сэлтийг үзэж харж, асууж лавлан ярилцахад шинжлэх ухаан-техник соёл, боловсролын холбогдолтой олон чухал зүйл улам тодорч, ноцтой анхаарагдан сонирхогдсоныг цохон тэмдэглэж, хагас заримыг ч гэсэн холбогдох байгууллага, нийт олны оюуны мэлмийд өртүүлж толилуулах санаа төрсөн юм.

Колоничлол, дайны хүнд хүчрийг үүрч гарсан нийт Солонгос орны умард, өмнөд аль аль хэсэг нь 1950-иад оны эхээр их л хоцрогдмол байдалд үлдсэний дээр 60-аад он гартал Өмнөд Солонгос нь хойтохоосоо илүүгүй, зарим талаар баахан дутуу дулимаг байжээ. Тухайн үед БН Солонгос улс гол анхаарлаа арга буюу хүнс тэжээл, нийт эдийн засгийн асуудалд хандуулж, шинжлэх ухаан-техникийн дэвшлийг дээд зэрэгт тавихаас өөр аргагүй байсан боловч огтхон ч хараанаасаа гаргасангүй. Угийн зах зээлийн чиглэлт аж ахуйтай энэ орон 60-аад оны үеэс гадаадын хөрөнгө оруулалт зоримог бөгөөд оновчтой хийж, 70-аад оны үест эдийн засгаа хөл дээр нь босгож авахын зэрэгцээ шинжлэх ухаан, техникийн дэвшлийн асуудлыг нэгэн зэрэг чухалчилж анхаарсан нь 80-аад оны үест үр дүнгээ өгсөн байна.

Уг нь Солонгост 1946 оны үеэс эхлэн Сеулын үндэсний их сургууль зэрэг их, дээд, тусгай мэргэжлийн дунд сургууль олон байгуулагдаж,